



Нийтийн эрх ашгийн сан, Монголын Эмнести интернэшнл, Цогц хөгжлийн үндэсний төв, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг их сургууль, Монгол улсын их сургууль, Чимид сан хамтран монголчуудын сэтгэлгээ, оюун санааны түүхэн өв болсон “УЛСЫН ЭРХ” бүтээлийн 111 жилийн ойг тохиолдуулан “УЛСЫН ЭРХ – 111” эрдэм шинжилгээний хурлыг 2 дахь жилдээ зохион байгуулсан.

Тус хуралд амжилттай оролцсон судлаачдын илтгэлийг хамтран зохион байгуулагчийн хувьд сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаарт нийтэлж та бүхэнд толилуулж байна.



ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE FACTORS INFLUENCING THE IMPLEMENTATION OF THE RIGHT AND FREEDOM OF PEACEFUL ASSEMBLY AND DEMONSTRATION

Эрдэнэбатын Хишигбайгаль¹

University of Internal Affairs, Mongolia, E-mail: khishigbaigali.e@uia.gov.mn,
<https://orcid.org/009-0000-2660-3289>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

ХУРААНГУЙ

158

Түлхүүр үгс:

Иргэдийн оролцоо, хамтын
ажиллагаа, хууль сахиулах
байгууллага, тайван
жагсаал цуглаан хийх эрх

Keywords:

Citizens' participation,
cooperation, law enforcement
agencies, and the right to
peaceful assembly and
demonstration

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 9 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Sep, 2025
Revised Oct, 2025
Accepted Oct, 2025

Бидний судалгааны ажлын зорилго нь иргэдээс тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтийг үнэлүүлэхэд орисон. Судалгаанд 18–61 насны 512 иргэнийг хамруулж, тайван жагсаал цуглаан хийх эрхийн хамгаалалтыг гурван хүчин зүйлийн хүрээнд тоон шинжилгээг Smart PLS-3.0, SPSS-27 программ ашиглан боловсруулалт хийсэн бөгөөд бүх хувьсагчийн найдвартай байдал өндөр ($\alpha = 0.94-0.97$) гарсан. Шинжилгээний дүнгээр зөвхөн иргэдийн оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт эерэг нөлөөтэй болох нь батлагдсан бол хамтын ажллагаа болон хууль сахиулах байгууллагын нөлөө батлагдаагүй.

Abstract

The purpose of our research was to assess citizens' evaluation of the exercise of the right to peaceful assembly and demonstration. A total of 512 citizens aged 18–61 participated in the study. Quantitative analysis of the protection of the right to peaceful assembly was conducted within three factors using Smart PLS-3.0 and SPSS-27 software. The reliability of all variables was high ($\alpha = 0.94-0.97$). The results revealed that only citizens' participation had a positive impact on the exercise of the right to peaceful assembly and demonstration, whereas the effects of cooperation and law enforcement agencies were not statistically significant.

Энэ өгүүлэл [CC BY-NC](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



¹Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн ахлах баги, докторант

1. Танилцуулга

Хүн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх бол шашин шүтэх, эс шүтэх эрхийн хамт хүний оюуны эрх, эрх чөлөөний гол цөм нь юм. Энэ эрх нь хүн юуны өмнө өөрийнхөө бодлыг хэрэгжүүлэх эсэхээ өөрөө шийддэг, оюуны үнэт зүйлийг хөхүүлэн дэмжих, ямар нэг зүйлд итгэх, эс итгэхээ шийдвэрлэх талаар аль нэг үзэл суртлын хяналтаас гадуур байхад оршино. Иймд итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө нийлээд хүний оюун ухааны угаас заяасан эрхийг бүрэлдүүлж байдаг.²

Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө юм. Энэхүү эрх, эрх чөлөөг хүмүүс дангаар бус хамтаар хэрэгжүүлдэг.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө нь Олон улсын гэрээ, тэр дундаа Олон улсын иргэний болон улс төрийн эрхийн пактын 21 дүгээр зүйлд хүний үндсэн эрхийн нэгээр баталгаажиг, ардчилсан нийгмийн тулгуур үнэт зүйл болдог. Монгол Улсад энэ эрх Үндсэн хуульд тусгагдсан хэдий ч эрх баригчдын болгоомжлол, хэт төвлөрсөн зохицуулалт, хүч хэрэглэх шалтгаалан бодитоор бүрэн хэрэгжихгүй байх тохиолдол бий. Тиймээс уг эрхийг иргэдийн идэвхтэй оролцоотой уялдуулан хэрэгжүүлэх нь улс төрийн оролцоог хангаад зогсохгүй, нийгмийн шударга ёс, эрх чөлөөг хамгаалах бат бөх үндэс болдог. Гэвч улс, үндэстнүүдийн геополитикийн нөхцөл байдал, эдийн засгийн чадавх, эрх зүйн уламжлал, эрх зүйн соёл, ухамсрын төвшингөөс хамаарч ТЖЦ хийх эрх, эрх чөлөөний баталгаа, хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйлс харилцан адилгүй байна.

Эрх зүйт ёсны шаардлагын хүрээнд төр хүний эрхийг хангах, хамгаалах хууль ёсны тогтолцоог бүрдүүлэх нь төрийн үндсэн үүрэг мөн болохыг үндэслэн Монгол улсын хувьд тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгааг хэрхэн бүрдүүлж байгаа болон түүнд нөлөөлж буй эерэг сөрөг хүчин зүйлсийг үнэлэх зорилгоор дараах таамаглалуудыг дэвшүүлж, хүчин зүйл тус бүрийг тодорхой хувьсагчаар үнэлж, тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгааг хангаж буй өнөөгийн байдлыг үнэлэхийг зорилоо.

2. Арга зүй

Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хамгаалалтыг гурван хүчин зүйлийн хүрээнд тоон шинжилгээг Smart PLS-3.0, SPSS-27 программ ашиглан боловсруулалт хийсэн.

3. Судалгааны үр дүн

Тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх онол, арга зүй

² Г.Совд, Н. Жанцан (2000 он). Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ хот: Монгол Улсын Хууль зүйн яам.

Жагсаал цуглаан хийх эрх нь ардчилсан нийгмийн тулгуур эрхийн нэг бөгөөд хувь хүн, төр, нийгмийн харилцааны зангилаанд орших эрх зүйн институц юм. Энэ эрхийн агуулгыг онолын үүднээс тайлбарлах нь түүний эрх зүйн мөн чанарыг ойлгох, улмаар хэрэгжилтийг үнэлэх онолын үндэс болдог. Тухайлбал, либерализм хувь хүний эрхийн суурь, нийгмийн гэрээний онол төр-иргэний үүргийн тэнцвэрийг тодорхойлдог бол позитивизм эрхийн хууль ёсны хэмжээг, иргэний нийгмийн онол оролцооны ач холбогдлыг, харин реализм бодит хэрэгжилтийн саадыг тус тус илчилдэг. Эдгээр онолын нэгдэл нь жагсаал цуглаан хийх эрхийн цогц ойлголт, хамгааллын тогтолцоог онолын түвшинд жагсаал цуглаан хийх эрхийн агуулгыг тодорхойлж, эрх зүйн болон нийгмийн уялдаа холбоог илэрхийлдэг.

Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх нь хүний үндсэн эрх, ардчиллын тулгуур эрхийн нэг бөгөөд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн механизм болдог. Уг эрхийг хэрэгжүүлэх нь иргэд өөрийн болон нийтийн эрх ашгийг хамгаалах, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын асуудлаар төр, олон нийтэд дуу хоолойгоо хүргэх, төрийн шийдвэрийг хянах боломжийг баталгаажуулдаг. Гэвч энэхүү эрх нь хууль ёсны хүрээнд хэрэгжиж, иргэдийн эрх чөлөө болон төрийн хууль ёсны ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалах шаардлагатай холбоотой бөгөөд энэ харилцан хамаарал нь тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хязгаарыг тодорхойлдог.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөнд зөвшөөрөгдөх хязгаарлалт ба түүний эрх зүйн үндэслэл:

<p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 21 дүгээр зүйлд заасан зөвшөөрөгдөх хязгаарлалтын төрлүүд:</p> <p>Үндэсний аюулгүй байдал: Эрх баригчид үндэсний аюулгүй байдал эсвэл олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хязгаарлалт тавьж болно. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гэж улс үндэстний оршихуй, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг хүчээр, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж үгүй хийхээс хамгаалах гарцаагүй шаардлагыг ойлгоно. Энэ үндэслэлд улс орны газар нутгийн зарим хэсэгт, хязгаарлагдмал хүрээнд хууль, дэг журам учирсан аюул заналаас сэргийлэх, зайлуулах үүднээс авах арга хэмжээ хамаарахгүй.</p> <p>Нийгмийн аюулгүй байдал: Жагсаал, цуглааны үеэр гэмт хэрэг, зөрчлөөс</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулиар Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.</p> <p>Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй байхаар хязгаарлалтыг тогтоож өгсөн байдаг.</p> <p>Монгол улсад Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд дараах хязгаарлалтыг</p>
---	---

<p>урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болно. Нийгмийн хэв журмыг хамгаалах гэдгийг тухайн улс төрийн олонлогийг бүрдүүлэгч суурь зарчмууд, хууль тогтоомж гэж ойлгоно. Хүний эрхийг хүндэтгэн сахих нь нийгмийн хэв журмын нэг хэсэг тул энэ үндэслэлээр тайван хуран чуулах эрх чөлөөг хязгаарлахдаа хамгаалж буй эрх зүйн зарчим ба тайван хуран чуулах эрх чөлөөний харьцаа, мөн чанарыг харгалзана. Аяндаа үүссэн цуглааныг хуулиар тогтоосон журмын дагуу бүртгүүлээгүй учраас албадан тараахыг нийгмийн хэв журмыг хамгаалах үндэслэлээр зөвтгөхгүй.</p> <p>Нийгмийн дэг журам: Олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах гэж хүмүүсийн аюулгүй байдал, амь нас, бие махбодын бүрэн бүтэн байдалд аюул учрах, эд хөрөнгөд ноцтой хохирол учрахаас хамгаалахыг хэлнэ. Тайван хуран чуулах эрх чөлөөнд хуулиар тогтоосон хязгаарлалтын ихэнх нь олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үндэслэлд хамаардаг боловч энэ үндэслэлийг хэт ерөнхий эсхүл дур зоргын байдлаар тайван хуран чуулах эрх чөлөөг хязгаарлахад ашиглах ёсгүй</p> <p>Нийгмийн эрүүл мэнд, ёс суртахуун: Хязгаарлалт нь нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үндэслэлтэй байж болно. Халдварт өвчний дэгдэлт үед цугларалт аюултай гэж үзвэл хязгаарлалт тогтоохыг зөвшөөрч болно. /Жагсаал, цуглааны үеэр ариун цэврийн нөхцөл байдал олон нийтийн болон оролцогчдын эрүүл мэндэд ихээхэн эрсдэл учруулж болзошгүй тохиолдолд/.</p> <p>Бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах: Бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гэж тайван хуран чуулах эрх чөлөөгөө хэрэгжүүлж байгаа хүмүүсээс бусад нийгмийн гишүүдийн Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан</p>	<p>тогтоосон. Үүнд:</p> <p>Нэг. Зорилгын хүрээнд.</p> <ul style="list-style-type: none"> - дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах; - үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох. <p>Хоёр. Онцгой нөхцөл байдлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг болон аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг хориглоно. <p>Гурав. Субьектийн хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> - Жагсаал, цуглааныг зохион байгуулах эрх Монгол Улсын иргэн, Улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, Төрийн бус байгууллага - Жагсаал, цуглаанд оролцох эрх Монгол Улсын иргэн Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Дөрөв. Объектын хүрээнд: - Нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч
---	---

<p>хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гарцаагүй шаардлагын үүднээс тогтоосон хязгаарлалтыг ойлгоно. Мөн нийтийн болон бусад орон зайг хууль ёсны дагуу ашиглах явдал хамаарна.</p>	<p>тээврийн төв буудал;</p> <ul style="list-style-type: none">- Цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар;- Радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар;- Олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах;- Эмнэлгийн байгууллага;- Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт. /Монгол Улсын Төрийн ордны тухай хууль/- Төрийн тусгай хамгаалалтын байнгын бүсэд
---	---

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь олон улсын хүний эрхийн системд баталгаажсан, ардчилсан нийгмийн тулгуур үнэт зүйлсийн нэг юм. Кристоф Хайнс (2020) энэхүү эрхийн онолын иж бүрэн үндэслэлийг олон улсын пактын 21 дүгээр зүйлд үндэслэн гаргаж, улс орнуудын эрх, үүрэг харилцан хамааралтай байгааг онцолсон.³ Анжа Бинерт (2024) тайван жагсаал, цуглаан хийх эрхийн олон улсын стандартыг хэрэгжүүлэх практик, онолын асуудлыг судалж, олон улсын үүрэг хариуцлага, үндэсний практик хоорондын уялдаанд тулгарч буй бэрхшээл, жагсаалын онцлогийн дагуу иргэдийн оролцоо хэрхэн идэвхжих эсвэл буурах нөхцөлийг тодорхойлсон.⁴

³ Бинерт, Анжа. (2024). *Практик и теоретические вопросы реализации права на мирные собрания и демонстрации: международные стандарты и национальная практика*. Berlin: Human Rights Press.

⁴ Хайнс, К. (2020). *Theoretical foundations of the right to peaceful assembly: International covenant perspectives*. New York: Global Human Rights Publishing.

Монгол Улсын судалгааны ажлуудад ч уг эрхийн хэрэгжилт, боломж, тулгамдсан асуудлуудыг авч үзсэн. Хүний эрхийн Үндэсний комисс (2004) 1989–2003 оны Монгол дахь тайван жагсаал, цуглааны төлөв байдал, эрх зүйн орчин, олон нийтийн үзэл бодлыг судалсан бол ЕАБХАБ (2011)-ын гарын авлага жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах, эрсдэлийн үнэлгээ хийх үндсэн зарчмуудыг танилцуулсан.⁵ Мөн О.Мөнхсайхан, Р.Очирбал (2021) судалгаандаа тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд тулгамдсан асуудал, стратеги, тактикийн төлөвлөлт, дэмжлэг, хүчирхийллийг удирдах аргачлалыг системтэйгээр дүгнэж, зөвлөмж боловсруулсан байдаг.⁶

Эдгээр судалгаануудын нэгдсэн дүн нь тайван жагсаал, цуглаан хийх эрхийг иргэдийн оролцоотой уялдуулан хэрэгжүүлэх нь зөвхөн улс төрийн оролцоог хангахаас гадна нийгмийн шударга ёс, эрх чөлөөг хамгаалах суурь болдог болохыг харуулж байна.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн уялдаанд хийсэн шинжилгээ

Бид 512 иргэдээс Монгол Улсад тайван жагсаал цуглаан хийх эрхийн хамгааллын тухай асуудлыг хөндөн хамаарах гурван хүчин зүйлийн хүрээнд асуумжаар чанарын судалгаа авсан. Судалгаанд оролцогчдын хувьд 18-61 настай иргэд хамрагдсан ба тэдний үнэлгээг нэгтгэн, кодолж, тоон судалгааны боловсруулалт хийн шинжилсэн.

Хүснэгт 01. Хүчин зүйлийн шинжилгээ

Хувьсагчид	Кодлол	Далд хувьсагчийн үр дүн	Нийлмэл найдвартай байдал	Кронбах альфа
Хууль сахиулах байгууллага	Law.en-1	0.945	0.969	0.957
	Law.en-2	0.946		
	Law.en-3	0.919		
	Law.en-4	0.955		
Иргэдийн оролцоо	Cit.par-1	0.886	0.966	0.957
	Cit.par-2	0.929		
	Cit.par-3	0.911		
	Cit.par-4	0.950		
	Cit.par-5	0.935		
Хамтын ажиллагаа	Co.ac-1	0.961	0.969	0.958
	Co.ac-2	0.942		
	Co.ac-3	0.934		

⁵ Хүний эрхийн Үндэсний комисс. (2004). Монгол Улсад тайван жагсаал, цуглааны төлөв байдал ба эрх зүйн орчин (1989–2003). Улаанбаатар: Хүний эрхийн Үндэсний комисс.

⁶ Мөнхсайхан, О., & Очирбал, Р. (2021). Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилт: тулгамдсан асуудал, стратеги, тактикийн удирдлага. Улаанбаатар: Социологийн судалгааны төв.

	Со.ас-4	0.932		
Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт	IRPD-1	0.622	0.953	0.941
	IRPD-2	0.867		
	IRPD-3	0.937		
	IRPD-4	0.919		
	IRPD-5	0.936		
	IRPD-6	0.907		
	IRPD-7	0.851		
	IRPD-8	0.691		


Тайлбар. Судалгааны ажлын үр дүн.

Бид чанарын асуулгаар авсан судалгааны өгөгдлийг тоон чанарын судалгаа болгон хувиргаж, хүчин зүйлийн дүн шинжилгээг далд хувьсагч бүрийн утга, нийлмэл найдвартай байдал (Composite Reliability, CR) болон Кронбах Альфа утгыг тооцоолон бодож нэгтгэсэн. Кронбах Альфа бүх хувьсагч дээр 0.94–0.97 хооронд тоон утга бүхий үр дүнтэй байгаа нь дотоод нийцэл маш сайн байгааг харуулсан.

Харин хувьсагч бүрийг шинжлэхэд, Хууль сахиулах байгууллагын далд хувьсагчид (0.919–0.955) хооронд хэлбэлзэж, $CR = 0.969$, $\alpha = 0.957$. Иргэдийн оролцоо (Cit.par) далд хувьсагчийн утга 0.886–0.950 хооронд хэлбэлзэж, $CR = 0.966$, $\alpha = 0.957$. тогтвортой байгааг харуулсан. Хамтын ажиллагаа хувьсагчийн далд утга (0.932–0.961) хооронд хэлбэлзэж, (Со.ас): $CR = 0.969$, $\alpha = 0.958$ байгаа нь найдвартай байдлыг баталсан. Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт (IRPD): $CR = 0.953$, $\alpha = 0.941$. Ихэнх ачаалал өндөр боловч IRPD-1 (0.622) болон IRPD-8 (0.691) нь бусад асуултаас харьцангуй доогуур байсан хэдий ч нийт найдвартай байдал өндөр хэвээр байна.

Бидний судалсан дөрвөн үндсэн хувьсагч (Хууль сахиулах байгууллага, Иргэдийн оролцоо, Хамтын ажиллагаа, Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт) нь бүгд өндөр найдвартай, дотоод нийцэлтэй хэмжилттэй байгааг шинжилгээний үр дүн баталлаа (Хүснэгт 01).

Загвар 02. Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ (Smart PLS 3.0)



Хүснэгт 02. Найдвартай байдлын шинжилгээний харьцуулалт

Үзүүлэлт	Кронбах альфа		Далд хувьсагчдын тоо
	SPSS-27.0	Smart PLS 3.0	
Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт	0.941	0.941	8
Иргэдийн оролцоо	0.952	0.957	5
Хамтын ажиллагаа	0.950	0.958	4
Хууль сахиулах байгууллага	0.958	0.957	4

Тайлбар. Судалгааны ажлын үр дүн.

Бид 512 оролцогчдыг хамруулсан судалгааны ажлын өгөгдөлд тоон дүн шинжилгээ хийхэд SPSS 27.0 ба SmartPLS 3.0-ийн үр дүн, тоон утга ойролцоо ба хэлбэлзэлгүй байна. Бүх хувьсагчдын Кронбах Альфа коэффициент 0.941–0.958 тоон утгын хооронд хэлбэлзэж, судалгааны асуулга тогтвортой, дотоод нийцэл сайтайг харуулсан. Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт” үзүүлэлт дээр хоёр программын тоо яг адил (0.941) байна. “Иргэдийн оролцоо”, “Хамтын ажиллагаа”, “Хууль сахиулах байгууллага” үзүүлэлтүүдэд 0.001–0.008-ийн багахан зөрүү гарсан боловч статистикийн ач холбогдолгүй, судалгааны үр дүнг сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байна (Хүснэгт 02).

Хүснэгт 03. Замын шинжилгээ

Таамаглал	Энгийн утга	Стандарт хазайлт	T статистик	П үнэ цэн	Үр дүн
Иргэдийн оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө.	0.610	0.239	2.607	0.009	Батлагдсан
Хамтын ажиллагаа нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө.	0.127	0.077	1.794	0.073	Батлагдаагүй
Хууль сахиулах байгууллага нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө.	0.182	0.242	0.648	0.518	Батлагдаагүй

Тайлбар. Судалгааны ажлын үр дүн.

Иргэдийн оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, энгийн утга = 0.610, П үнэ цэнэ 0.009 (<0.05) үр дүнтэй гарч, таамаглал батлагдсан. Хамтын ажиллагаа нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, энгийн утга = 0.127, П үнэ цэнэ 0.073 (>0.05) үр дүн гарч таамаглал батлагдаагүй. Хууль сахиулах байгууллага нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, энгийн утга = 0.182, П үнэ цэнэ 0.518 (>0.05) үр дүн гарч таамаглал батлагдаагүй (Хүснэгт 03).

Хүснэгт 05. Хамаарлын шинжилгээ

Таамаглал	[1]	[2]	[3]	[4]
-----------	-----	-----	-----	-----

Иргэдийн оролцоо [1]	0.923			
Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт [2]	0.870	0.848		
Хамтын ажиллагаа [3]	0.684	0.671	0.942	
Хууль сахиулах байгууллага [4]	0.969	0.855	0.679	0.941

Тайлбар. Судалгааны ажлын үр дүн.

Иргэдийн оролцоо ба Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт $r = 0.870 \rightarrow$ маш өндөр эерэг хамааралтай, Иргэдийн оролцоо ба Хууль сахиулах байгууллага $r = 0.969$ өндөр эерэг хамааралтай, Иргэдийн оролцоо ба Хамтын ажиллагаа $r = 0.684 \rightarrow$ дундаас дээш түвшний эерэг хамааралтай, Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт ба Хууль сахиулах байгууллага $r = 0.855$ эерэг хамааралтай, Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт ба Хамтын ажиллагаа $r = 0.671$ эерэг хамааралтай, Хамтын ажиллагаа ба Хууль сахиулах байгууллага $r = 0.679$ дундаж эерэг хамааралтай үр дүн тус тус гарсан (Хүснэгт 04).

Дөрөв. Дүгнэлт

Судалгаанд 18–61 насны 512 иргэнийг хамруулж, тайван жагсаал цуглаан хийх эрхийн хамгаалалтыг гурван хүчин зүйлийн хүрээнд асуумжаар судалж, чанарын өгөгдлийг тоон судалгааны аргаар боловсруулсан.

167

Хэмжилтийн найдвартай байдлын шинжилгээгээр бүх хувьсагчийн Кронбах альфа 0.94–0.97 хооронд гарч, дотоод нийцэл маш сайн болох нь тогтоогдсон.

Хууль сахиулах байгууллага ($CR = 0.969$, $\alpha = 0.957$), Иргэдийн оролцоо ($CR = 0.966$, $\alpha = 0.957$), Хамтын ажиллагаа ($CR = 0.969$, $\alpha = 0.958$), Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт ($CR = 0.953$, $\alpha = 0.941$) бүгд өндөр найдвартай байдалтай байна.

Таамаглалын шинжилгээгээр зөвхөн иргэдийн оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд статистикийн ач холбогдолтой эерэг нөлөөтэй ($p = 0.009 < 0.05$) болох нь батлагдсан.

Харин хамтын ажиллагаа ($p = 0.073 > 0.05$) болон хууль сахиулах байгууллагын ($p = 0.518 > 0.05$) нөлөө статистикийн хувьд ач холбогдолгүй тул таамаглал батлагдсангүй. Хамаарлын шинжилгээний дүнгээс харахад, иргэдийн оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилт ($r = 0.870$) болон хууль сахиулах байгууллагатай ($r = 0.969$) хамгийн өндөр хамааралтай, харин хамтын ажиллагаа бусад хувьсагчидтай дундаж түвшний хамааралтай байсан.

Судалгааны ажлынхаа үр дүнгээс дараах хоёр санал дэвшүүлсэн. Үүнд:

Иргэдийн оролцоог дэмжих нь зүйтэй. Иргэдийн идэвхтэй оролцоо нь тайван жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэд эерэг, ач холбогдолтой нөлөө үзүүлж байгаа тул эрхийн хэрэгжилтийг сайжруулахын тулд иргэдийн оролцоог идэвхжүүлэх стратегийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Бусад хүчин зүйлүүдийн нөлөөг сайжруулах шаардлагатай. Хамтын ажиллагаа болон хууль сахиулах байгууллагын нөлөө ач холбогдолгүй байгаа нь эдгээр хүчин зүйлсийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийн оролцоотой уялдуулан тайван жагсаал цуглааны эрхийн хэрэгжилтийг бэхжүүлэх боломжийг харуулж байна.

Эх сурвалж

- Г.Совд, Н. Жанцан (2000 он). Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ хот: Монгол Улсын Хууль зүйн яам.
- Бинерт, А. (2024). *Практик и теоретические вопросы реализации права на мирные собрания и демонстрации: международные стандарты и национальная практика.* Berlin: Human Rights Press.
- Хайнс, К. (2020). *Theoretical foundations of the right to peaceful assembly: International covenant perspectives.* New York: Global Human Rights Publishing.
- ЕАБХАБ. (2011). *Guidelines on maintaining public order and risk assessment during assemblies and demonstrations.* Vienna: Organization for Security and Co-operation in Europe.
- Хүний эрхийн Үндэсний комисс. (2004). *Монгол Улсад тайван жагсаал, цуглааны төлөв байдал ба эрх зүйн орчин (1989–2003).* Улаанбаатар: Хүний эрхийн Үндэсний комисс.
- Мөнхсайхан, О., & Очирбал, Р. (2021). *Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилт: тулгамдсан асуудал, стратеги, тактикийн удирдлага.* Улаанбаатар: Социологийн судалгааны төв.

Судалгааны ажлын баримтжуулсан мэдээлэл

2025.08.20.splsm | bodoh 0909.txt | *08.splsm | Bootstrapping (Run No. 7)

Path Coefficients

Mean, STDEV, T-... | Confidence Inte... | >> 2 | Copy to Clipboard: Excel Format | R Format

	Original Sampl...	Sample Mean (...)	Standard Devia...	T Statistics (O/...	P Values
Иргэдийн оро...	0.624	0.610	0.239	2.607	0.009
Хамтын ажил...	0.138	0.127	0.077	1.794	0.073
Хууль сахиула...	0.157	0.182	0.242	0.648	0.518

2025.08.20.splsm | bodoh 0909.txt | *08.splsm | Bootstrapping (Run No. 7) | PLS Algorithm (Run No. 1)

C:\Users\HappyJoy\smartpls_workspace\2025.08.20\2025.08.20.splsm

Discriminant Validity

Fornell-Larcker Criterion | Cross Loadings | Heterotrait-Monotrait Ratio (HTMT) | Heterotrait-Monotrait Ratio (HTMT)

	Иргэдийн оролцоо	ТЖЦХЭЭ-ний хэрэгжилт	Хамтын ажиллагаа	Хууль сахиулах байгууллага
Иргэдийн оролцоо	0.923			
ТЖЦХЭЭ-ний хэрэгжилт	0.870	0.848		
Хамтын ажиллагаа	0.684	0.671	0.942	
Хууль сахиулах байгууллага	0.969	0.855	0.679	0.941